*Доод девоны хувирмал карбонат-терриген уст бүрдэл /D<sub>1</sub>:* Доод девоны хувирмал карбонат-тригген уст бүрдэл талбай орчмын нутагт бага хэмжээтэй тархсан байдал. Ус агуулагч чулуулгууд ан цавархаг гантигжсан шохойн чулуу, алевролит, элеэн чулуугаас бүрдэнэ. Эдгээр чулуулаг нилээн сул усжилгтай. Чулуулгуудын усжилтын хэмжээ ан цавшилт, тэдгээрийн хоорондын холбоо, нэвчих гүнээс ихээхэн хамаардаг. Гэвч уг чулуулаг нь маш бага тархалттай байдал нь усны хэмжээний хувьд ач холбогдолгүй болж байна.

*Түрүү пермийн гунийн интэрүүз уст бүрдэл / γРγ/:* Цахиурт овоогийн орд түүний ойр орчимд хамгийн өргөн бөгөөд том талбайд тархсан уст бүрдэл бол түрүү пермийн настай боржингийн биетүүд юм. Балла нар 1:200000 харьцалтай зураглалын үеийн гедрогеологийн судалгаагаар уг ус агуулагч боржин ан цавархаг болон бутралын бүсүүдтэй бөгөөд тэдгээр бүсүүдийн хамгийн дээд зузаан нь 10-15м бөгөөд гүнрүү ан цавшилт аажмаар багасдаг. Эдгээр бүсүүд нь ус агуулагч гол орон зай болдог байна. Газар доорхи усны төвшин 3,0-21 м гүнд оршидог. Цооногийн ундратаа 0,08-0,1 л/с хэмжээтгэй. Усны түвшиний бууралт 1,8-8,1 м. Шүүрэлтийн итгэлцүүрийн дундаж утга 0,32 м/хоног. Ус өгөлтийн нэтгэлцүүр  $10^{-7}$ - $10^{-8}$  м<sup>2</sup>/хоног. Эдгээр үзүүлэлтээс үзвэл боржин маш сүл усжилттай нь харагдаж байна. Усны химийн найрлаганд гидрокарбонат болон сульфатын ион зонхилен. Усны эрдэсжилт 0,3-0,5 г/л. Усны ерөнхий хатуулаг 2,3-5,2 мг/экв фторын агуулга 0,9 мг/л. Уран илрээгүй. Энэ бүс нутагт орд ашиглалтын явцад илрэх усны урсацны хэмжээг /водоприток/ 0,27 л/с хэмжээтгэйгээр үнэлсэн нь ордын гедрогеологийн ажиглалтын тааламжтай нөхцлийг харуулж байна.

*Доод цэрдийн вулканоген-терриген уст бүрдэл. Зүүнбаян формац/:* Тусгай зөвшөөрлийн талбайн хойд, баруун болон өмнөд хэсгээр доод цэрдийн настай зүүнбаян формацын хүрэн бор өнгөтэй цул, нух сувэрхэг, заримдаа миндалин чулуут (мана) андезитобазалт, базалт, там хайргат конгломерат, гравелит, элсэн чулуу алевролит тархсан байдаг. Тэдгээрийн гарш бага талбайтай бөгөөд дөрөвдөгчөөр хучигдаж, жижиг толгод, дөвүн оройгоор илрэсэн байна. Дээрх терриген чулуулагт агуулагдах ус нь нилээд ундраг сайтай болох нь өмнөх судлаачдын материалын харагдаж байна. Түүний усны урсацны хэмжээг /водоприток/ 2,2 л/с хүрдэг байна.

*Дөрөвдөгчийн делови-проловийн гаралтай сэвсгэр /Хурдсанд тархсан уст үе /Q//:* Делови-проловийн гаралтай хурдас хуурай сайр, хөндийгөөр өргөн тархсан. Зарим хөндий, хотгорт давстай жижиг нуур, тойром үүссэн байдаг. Эдгээрийн усний хэмжээ хур тундасны устай шууд хамааралтай. Ус агуулагч чулуултууд элс хайрга шавранцар дайрга болон чулуун том хэмжээний хэмхдэснээс бүрдэнэ. Дөрөвдөгчийн хурдсын зузаан нь 30м-ээс ихгүй бөгөөд хамгийн их зузаан нь томоохон хөндийн төв хэсгээр оршино. Хуурай сайрууд, хөндийд усны төвшин 2,5-7,28 м-ийн гүнд оршино. Эдгээрт гаргасан уурхайн худгууд нь нутгийн оршин суугчдын хүн малын ундны хэрэгцээний гол эх үүсвэр болдог. Тэдгээр худгийн ундратаа 0,6-0,7 л/с, усны эрдэсжилт 0,6-0,7 г/л.

## ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

“Эм Эл Цахиурт овоо” ХХК-ийн “Цахиурт-Овоо” төмрийн молибденийн ордыг ил аргаар ашиглах, нойтон соронзон аргаар баяжуулах үйлдвэрийн төслийн хэрэгжүүлэх үед байгаль орчинд дараах гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг үзүүлэх болно.

Хүснэгт 13. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

1	Төслийн гол нөлөөлөл	Нөлөөлөлд өртөгч	Хамрах хүрээ	Нөлөөллийн эрчим	Үргэлжлэх хугацаа
1	Хөрс хуулалт	Газрын хөрс, бэлчээр, агаар	Урхайлалтанд 109га талбай эвдрэлд өртөнө	Хүчтэй	Төсөл хэрэгжих хугацаанд
2	Олборлолт	Геологийн тогтоц, гүний ус, агаар	Жилд 4 760.0 мян.тн хүдэр олборлож төслийн эхний 5 жилийн хугацаанд 6 609.9 мян.тн хүдэр олборлох ба 33,6 га талбай эвдэрнэ /Ил уурхайн омно нь ортсон ба одоо өртөгдөх талбай/.	Хүчтэй	-“-
3	Тээвэр	Хөрс, агаар	Зөвхөн АМТЗ-ийн талбайгаар тооцоход уурхайн дотоод технологийн замуудад 1.6 га орчим талбай хамрагдах ба түүнээс босох тоос шороо болон дотоод шаталтат хөдөлгүүртэй тээврийн хэрэгсэлийн яндангаас гарах бохирдуулагч хий зэрэг ялгарч агаар орчныг бохирдуулна.	Дунд зэрэг	-“-
4	Овоолго	Хөрс, агаар, шимт хөрс	Хөрсний ілтгээгээд 48.3 га, шимт хөрсний овоолгод 9.1га, хүдэрийн овоолгод 1.4га, хаягдлын овоолгод 5.3га ід: èì òàééàé /нийт 64.1 га/ дарагдана.	Хүчтэй	-“-
	Ил уурхайн шүүрлийн ус	Газрын доорх гүний усны нөөц,	Судалгааны үр дүнд ус шүүрэлтийн итгэлцүүр 0.32м/хоног, ус дамжуулалтын итгэлцүүр 10 м2/хоног ус агуулсан ан цавшилтын бүсийн зузаан нь 10м. Том худгийн агаар тооцсон ил уурхайд орж ирэх усны хэмжээг 193м3/хон. буюу 8м3/цаг /2.2 л/с/ байна /ТЭЗҮ/	Дунд зэрэг	-“-
5	Баяжуулах үйлдвэр	баяжуулах үйлдвэрээс агаарт хаягдах тоосжилт	Баяжуулах үйлдвэрт нийт 2 ширхэг босоо тоос баригч сууринтуулсан ба үйлдвэрийн шат дамжулагууд битүү орчинд явагдах учир гадаад орчинд хаягдах нь харицангуй бага байна.	Дунд зэрэг	-“-
6	Баяжуулах үйлдвэрийн усны хэрэглээ	Газрын доорх гүний усны нөөц,	Төслийн эхний 5 жилийн хугацаанд 12 870.2 мян.м <sup>3</sup> ус баяжуулах үйлдвэрт ашиглагдана. Үүний 70%-ийг эргэлтийн усаар хангах ба 30%-ийг /3 056.8 мян.м <sup>3</sup> / нөхөн сэлбэлтээр авч ашиглана.	Хүчтэй	-“-

## БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

2025 онд Байгаль очинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дугээр зүйлийн 9.5-д заасны дагуу Байгаль орчны менежментийн төловслогөө (БОМТ)-г БОАЖЯ-ны шийдвэрээр Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг баталгаажуулсан. Байгаль орчинд нөлөөлөнх байдлын нарийвчилсан үнэлгээнд тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээг уг төслийн хэрэгжих нийт хугацааны эхний 5 жилд хэрэгжих байдлаар тусгасан байна.

2025 онд мөрдөж хэрэгжүүлэх байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хотолбөр нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний хүрээнд Сүхбаатар аймгийн Уул баян сумын нутагт хэрэгжинэ.

Орчны хяналт-шинжилгээний хотолбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд гарч байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгасан болно. Бид 2025 онд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд дараахи гол зорилтуудыг тавьж ажиллах болно. Үүнд:

- Байгаль орчны хяналт шинжилгээний хотолбөрийг сайжруулж, түүнд нутгийн иргэдийг оролцоог хангах, дэмжих ажлыг үргэлжүүлэн хийнэ.
- Уурхайн эдэлбэр газарт ногоон байгууламж нэмэгдүүлэх
- Уурхайн усны менежментийг сайжруулж, хог хаягдлын хэмжээ, түүний байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор шат дараатай арга хэмжээ хэрэгжүүлэн ажиллана.
- Үйлдвэрийн бүс болон уурхайн орчмын иргэдэд уурхайн нөлөөлөлийн бүсийн эрдэл түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх талар мэдээлэл олгох хамтран ажиллах
- Үйлдвэрийн үйл ажиллагаанаас байгаль орчин болон эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхүйц үр дагаврын тухайн нутгийн иргэдээс мэдээлэл өгөх явдлыг урамшуулж ажиллана.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилтоо биелүүлэхийн тулд Монгол улсын хууль тогтоомж, дурэм журам, стандарт, тухайн жилийн байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хотолбөрийг барьж ажиллах болно.

## БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний салшгүй нэг хэсэг бол байгаль хамгаалах төлөвлөгөө бөгөөд энэ төслийн үйл ажиллагааны явцад хүрээлэн буй орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, үссэн нөлөөллийг бууруулахад барьж ажиллах төлөвлөгөө болно. Төлөвлөгөөний хэрэгжилтэд “Байгаль орчныг хамгаалах тухай”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай”, “Усны тухай”, “Газрын тухай зэрэг хууль тогтоомжинд заасны дагуу төрийн захиргааны төв орон нутгийн байгууллагауд хяналт тавьж хэрэгжилтийг хангулна.

### I. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 14. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ

Болзошгүй сөрөг нөлөө	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Цар хүрээ	2025 оны нэгжийн ортог	Биелэлтийн шалгуур	Баримтлах шалгуур стандарт
Уурхайн олборлолт болон тээврийн хэрэгслүүдийн үйл ажиллагааны улмаас гарч болох тоосжилтын агаар бохирдуулах эх үүсвэрүүд:	Машин техникиүүдийн янданд Шүүлтүүр суурилуулж, найдвартай ажиллагааг хангах, ялгаруулж буй хорт хийн түвшинд хяналт тавих болон янданд оч баригч хийх	Төсөлд хэрэглэгдэх машин, техникиүүд	1500	Машин техникиүүдийн янданд шүүлтүүр суурилуулж, техникийн үзлэг, шалгалтанд тогтмол оруулсан байх	M^8 5013:2003 бензин хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагч ид,
Уурхайн үйл ажиллагаанд ашиглаж буй тээврийн хөдөлгөөн, Тээвэрлэлтэнд явж буй машинуудаас ялгарах хорт бодисуудаар орчны агаар бохирдох	Төслийн үйл ажиллагаанд Ашиглагдах тээврийн хэрэгслүүдийг техникийн үзлэг, шалгалтанд тогтмол оруулж, засвар үйлчилгээг тогтмол чанартай хийх	Төсөлд хэрэглэгдэх машин, техникиүүд	1000		M^8 5014:2003 дизель хөдөлгүүрээс ялгарах бохирдуулагч ид
	Бутгуурын тоос баригчийн бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах	Баяжуулах үйлдвэр	-		БОС-ын 1995 оны 153 тоот тушаал
	Тоосжилтыг бууруулах зорилгоор хуурайшилттай уед	Төслийн талбайд	4500	Төслийн талбай	M^8 4585 :2016

	зам талбайг тогтмол услаж байх				
Тэсэлгээний ажлын үед үүсэх тоосжилт	Хуурай хог хаягдлыг хогийн цэгт зайлцуулахгүйгээр шатаахыг хориглоно		Үйл ажиллагааны зардал	Хог хаягдлын сургалт, бүртгэл	Зөрчлийн тухай хуулийн 6 дугаар бүлгийн 6.1-ийн 2
<b>Нийт</b>	<b>7000</b>				
<b>Газрын гадарга, хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө</b>					
Хөрсний овоолго болон уурхайн олборлолтоор сүйтгэгдэх хөрс	Уурхай ухаан, барилга баригдах талбайн шимт хөрсийг стандартын дагуу хуулж, хадгалах	Ил уурхай	Үйл ажиллагааны зардлаар	Шимт хөрс 0.2м-ийн зузаантайгаар хуулж тусгай овоолго хийж хадгалсан байна	M^8 5916:2008
	Талбайд болон ойр орчинд олон салаа зам гаргахгүй нэгдсэн сүлжээг сайжруулж, тэмдэг тэмдэглэгээг байршуулах	Төслийн талбайн хэмжээнд	500.0	Сайжруулсан тогтсон маршруттай замтай, тэмдэг тэмдэглэгээ байх	
Газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан номрөг үйлдвэрийн барилга байгууламжид, зам талбайд дарагдаж элэгдэл эвдрэлд орох	Төслийн ерөнхий төлөвлөгөөний дагуу орчны тохижилт, ногоон байгууламжийн ажлыг заавал бүрэн гүйцэд хийх	Төслийн талбай	Үйл ажиллагааны зардлаар	Ерөнхий төлөвлөгөөний дагуу орчны тохижилт, ногоон байгууламжийг бүрэн гүйцэд хийсэн байх	
	Хатуу хог хаягдлын цэгийг сайжруулах	Хатуу хог хаягдлын цэг	300	Хог хаягдлын цэг байгуулсан байх	
<b>Нийт</b>	<b>800.0</b>				
<b>Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө</b>					
	Барилга барих, явган замаас бусад талбайн ургамлыг талхлагдлаас хамгаалах, тогтсон нэг замаар уул тээврийн машиныг явуулах, байгаль орчны сургалтад операторуудыг хамруулах	Төслийн талбайн хэмжээнд	300,0	Хайс хамгаалалтыг нэмж байгуулах, тэмдэгжүүлэлт хийгдэж, хамгаалагдсан байх	Байгаль орчныг хамгаалах тухай хууль 31 зүйл, Ургамал хамгааллын тухай хууль

<b>Хүдэр олборлолт, боловсруулалт, тээвэрлэлийн нөлоөллюөс болж ургамлан бүрхэвч дорийтох, хомсдох,устаж угий болох цаашид бэлчээрийн доройтолд орох</b>	Шаардлагагүй салаа зам гаргаж ургамлыг талхлагдахаас урьдчилан сэргийлэх  Төслийн талбайд хуурай хээрийн ургамал зонхилон тархсан, хуурайшилт ихтэй үед Хээрийн болон объектийн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, ажилчдыг сургалтад хамруулах  Хог хаягдлыг тогтмол хугацаанд цэвэрлэж, аймгийн ОНӨтҮГ-тай гэрээ байгуулан хамтран ажиллах, хогийн цэгт хүргүүлэх, аюултай хог хаягдлыг	Төслийн талбай  Төслийн талбай орчимд	Үйл ажиллагааны зардлаар  250,0	Шинээр зам гаргаагүй байх  Гал түймрийн хэрэгсэл, галын дүгнэлт  Хог хаягдлын маягтаар	Байгалийн ургамлын тухай хууль 7 дугаар зүйл
<b>Нийт</b>	550,0				
<b>Гадаргын ус болон газрын доорх ус</b>					
<b>Усны зохистүй хэрэглээ бий болохоос үүдэн газрын доорх нөөц хомсдох</b>	Уурхайн усны хэрэглээнд хяналт тавьж сар бүр тоолуурын заалтыг актаар баталгаажуулан бүртгэх.	Уурхайн ажилчдын тосгоны гадна болон дотор, засварын үйлчилгээний төв, гаалийн хяналтын талбайн худаг	-	-	-
	Нийт ажилчдад Усыг зүй зохистой ашиглах усан орчны танин мэдэхүйн мэдээлэл хүргэх.	Уурхайн ажилчид	1000		
<b>Газрын доорх усны нэг ўе давхаргад Хамаарах үндны Усны эх үүсвэрт нөлөөлөх</b>	Уурхайн бүсийн ойролцоо байх малчдын худагт усны түвшний хэмжилт хийж өөрчлөлтийг хянах. Мөн pH, EC, температур зэрэг үзүүлэлтийг хэмжих	Уурхайн бүсийн ойролцоо байх малчдын худаг	Үйл ажиллагааны зардалд тусгах	Хэмжилтийн дүн	

<b>Ариун цэврийн /00-ийн/ байгууламжийн битүүмжилсэн цооногт хяналт тавих газрын доорх ус бохирдохоос сэргийлэх.</b>	Цэвэрлэх байгууламжийн оролт гаралтын хэсгээс дээжлэлт хийн усны цэвэршилтийн түвшин болон ахуйн хаягдал бохир усанд агуулагдах бохицуудагч бодисын агууламжийг тодорхойлох шинжилгээг хийлгэх.	Уурхайн бус	Орчны хяналт шинжилгээний зардлаар	Шинжилгээний дүн	<b>M^84943:2015, M^8 6561:2015</b>
<b>Ил уурхайд шүүрэн орж ирэх усыг удаан хугацааны турш шавхан зайлцуулсанаар тухайн орчмын газрын доорх усны түвшин буурч, нөөц багасах, шавхан зайлцуулсанаар тухайн орчмын газрын доорх усны түвшин буурч, нөөц багасах</b>	Цооног, худгийн түвшин хэмжих	Уурхай орчимд байрлах малчдын худаг, Уурхайн мониторингийн цооногуудад	Дотоод зардлаар	Мониторингийн цооногуудын бүрэн бүтэн байдал, хэмжитийн дүнгүүд	<b>Усны тухай хууль Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль М^8 4288:1995</b>
	Ус ашиглуулах дүгнэлт гаргуулах	Төслийн хэмжээнд	Жил бүр	Ус ашиглах дүгнэлт	
	Усны боломжит нөөцийн дүгнэлт болон ус ашиглах дүгнэлтэд заасан хэмжээнээс давуулалгүй усыг ашиглах		Бодлогын түвшинд		
<b>Нийт</b>	<b>100.0</b>				

## 2. Нөхөн сэргээлт, тохижолтын ажлын төлөвлөгөө

Хүснэгт 15. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Хийгдэх ажил	2025
Нийт тарих мод	500
Суулгацын үнэ	6500
Хөөрс сайжруулалт	7,500,000.00
Суулгацын үнэ	3,225,000.00
Усалгааны зардал	77,700.00
Нийт	10,827,700.00

## 3. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 16. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Үрьдчилан сэргийлэх, хамгаалахарга хэмжээ	Арга хэмжээний цархэмжээ	2025 оны нэгжийн өртөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	<b>Ахуйн болон үйлдвэрлэлийн гаралтай /энгийн болон аюултай/ хог хаягдлын нөлөөгөөр хөрс, ус, агаар бохирдох, ажилчдын эрүүл мэндэд сергөөр нөлөөлөх</b>	Хог хаягдлыг ангилан ялгаж, дахин ашигладаг тогтолцоог нэвтрүүлэх	Төслөөс гарах хог хаягдал	Үйл ажиллагааны зардлаас	2024-2028	Хог хаягдлын тухай хуулийн 9-р зүйл
2		Төслийн талбайд үүссэн бүх хатуу хог хаягдлыг нэгдсэн цэгт түр хуримтлуулан цуглуулж, ангилах	Төслөөс гарах хог хаягдал	1050,0	2024-2028	
3		Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх, ажилчдын байр, оффис, агуулах, ШТС зэрэг газарт байрлуулах, ариутгал, засварлаж байх	Төслийн хүрээнд	1000,0	2024-2028	Хог хаягдлын тухай хуулийн 15-р зүйл
4		Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх	Төслийн хүрээнд	Үйл ажиллагааны зардлаас	2024-2028	Хог хаягдлын тухай хууль”

5	Хийсч тархсан болон үүссэн хог хаягдлын овоолгыг тогтмол цэвэрлэж хэвших	Ашиглалтын талбай болон түүний ойр орчимд	Үйл ажиллагааны зардлаас	Сар улирлаар, 2024-2028	
6	Хог хаягдлын хор уршиг, ангилан ялгах талаар ажиллагсдад сургалт явуулах, хогхаягдлын мэдээллийн сангийн бүртгэл хетлех	Төслийн хэмжээнд	600,0	2024-2028	Хог хаягдлын тухай хууль”
7	Ахуйн гаралтай хатуу хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх, эх үүсвэр дээр нь ангилах	Төслийн хэмжээнд	750,0	Жил бүр Улиралд нэг удаа	Хог хаягдлыг тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2017-05-12
8	Үйл ажиллагааны явцад гарсан аюултай хог хаягдлыг ангилан ялгах, хадгалах, устгах, зайлцуулах /133-р хүснэгт болон 4.9 дүгээр бүлэгт заасан зөвлөмжийг мөрдөж ажиллах/	Төслийн хэмжээнд	400.0	Жил бүр Улиралд нэг удаа	
	<b>Нийт</b> <b>3800.0</b>				

#### 4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг 3.1.11-д “Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах” гэжтөслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг ойлгоно гэж заасан байdag.

Төсөл хэрэгжүүлэгчийн дүйцүүлэн хамгааллын арга хэмжээг тодорхойлохдоо Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-117 тоот тушаалаар батлагдсан Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх аргачлалын БОМТ боловсруулах хэсгийн Дүйцүүлэн хамгаалтай холбоотой аргачлал зөвлөмжийг баримтлав.

Ашигт малтмалын ашиглалтын нөлөөлөлд өртөж буй биологийн олон янз байдлыг тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд, өөр газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлага бий болсон тул, төслийн нөлөөлөлд өртсөн ба Дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрын хэмжээг тогтоох, дүйцүүлэн хамгаалахаар тогтоогдсон газар нутгийн байршлыг сонгох, биологийн олон янз байлдлын суурь судалгаа хийх биологийн олон янз байдлыг хамгаалах, сайжруулахад чиглэгдсэн хамгааллын менежментийн багц арга хэмжээг тогтоох, мониторинг хийх хөтөлбөр зохиох, төсөв, санхүүжилтийн төлөвлөгөө гаргах гэсэн үндсэн шат дараалалтайгаар дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөг боловсруулав.

Хүснэгт 17. Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө

Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгааллын арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нэгжийн өртөг /сая.төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт аргачлал
	Уул уурхайн улмаас эвдрэлд орон орхигдсон талбайд нөхөн сэргээлт хийж сум орон нутагт хүлээлгэн өгөх	Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутагт Бумбат нэртэй газарт эвдрэлд орсон талбайгаас 1 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийх	9.6сая	2025оны 3-р улиралд	Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-117 тоот тушаал

## 5. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

“Цахиурт-Овоо” төмрийн хүдрийн ордын хүдрийг нойтон соронзон аргаар баяжуулах үйлдвэр, ус хангамжийн байгууламжийн үйлдвэрлэлийн болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд орших иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллагыг зайлшгүй нүүлгэх шаардлагатай болсон тохиолдолд тэднийг нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө боловсруулна гэж байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд заасны дагуу 2014 оны 07-р сард нутгийн малчин Н.Амарсанаагийн өвөлжөө баяжуулах үйлдвэрийн талбайд байсаныг нүүлгэн шилжүүлж харилцан тохиролцон гэрээ байгуулж зохих нөхөн олговрыг олгосон болно.

Одоо ашиглалтын талбай болон бусад үйл ажиллагаа явуулах талбайнуудад ямар нэгэн айлын өвөлжөө, хаваржaa байхгүй тул цаашид нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ авахгүй.

## 6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Тус компани нь Сүхбаатар аймгийг Уулбаян сумын нутаг дахь ашиглалтын MV-015610 А тоот тусгай зөвшөөрөл бүхий талбайд орших археологийн дурсгалыг авран хамгаалах малтлага судалгааны ажлыг 2011 оны 09 дүгээр сарын 20-оос 10 дугаар сарын 20-ыг хүртэл 30 хоногийн хугацаанд Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Археологийн Хүрээлэнгээр хийлгэсэн.

Энэхүү MV-015610 А тоот ашиглалтын талбайд байсан дурсгалуудыг Монгол Улсын Соёлын Өвийг хамгаалах тухай хуулийн 6 дугаар бүлгийн 17 дугаар зүйлийн 10-т заасныг үндэслэн авран хамгаалах малтлага судалгаа хийж тухайн ашиглалтын талбайг чөлөөлсөн байна.

Уг тусгай зөвшөөрлийн талбайд цаашид хийх геологи хайгуулын болон олборлолтын явц түүний дэд бүтцийн барилгажилтын ажил гарах нөхцөлд эртний түүх соёлын ямар нэгэн дурсгал өртөхөөргүй болсон тул цаашид түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээг авахгүй.



Зураг 17. Ашиглалтын талбай дахь Археологийн дурсгалыг авран хамгаалах малтлага  
судалгааны ажлын ул мөр

## 7. Химийн бодисын эрсдэлийн менежменийн төлөвлөгөө

Энэ төлөвлөгөөнд батлагдсан аргачлалын дагуу хийсэн байгалийн аюул, гамшгийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, химийн бодисын эрсдэлийн үнэлгээний дунд тогтоосон аюултай болон хортой химийн бодис алдагдахаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийг аюулгүй хадгалах, ашиглах аргахэмжээг хэрэгжүүлэх ажлын хэмжээ, шаардагдах зардал, баримтлах стандартыг энд тусгасан болно.

**Хүснэгт 18. Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөө**

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг (сая.төгр)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Байгалийн болзошгүй гамшиг, аюулт үзэгдлээс үүдэн төслийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, дам нөлөөллөөр хүрээлэн буй орчныг бохирдуулах	Цаг агаарын улирлын, сарын, долоо хоногийн, өдрийн урьдчилсан мэдээнүүдийг төслийн үйл ажиллагаанд байнга ашиглах  Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, болзошгүй аюулын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулах  Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, галын хор зэргийг тогтсон стандартын дагуу байрлуулж бэлэн байдлыг хангаж ажиллах	Үйлдвэр ажиллах хугацаанд төслийн нийт арга хэмжээнд  Төслийн хэмжээнд	Үйл ажиллагааны төсөвт суулгах  2.0	Үйл ажиллагааны турш  2-р улиралд	Компанийн онцгой байдлын үед ажиллах төвөвлөгөө  Галын аюулгүй байдлын тухай хууль, 16-р зүйл, М^85566:2008 М^80640:89 М^8639:89

	Хотхон ба баяжуулах үйлдвэр, ил уурхайг хаврын шар усны болон хур борооны үерээс хамгаалах арга хэмжээ авах	Төсөл хэрэгжиж буй талбайд	ҮА-ны зардлаар	Үйл ажиллагааны турш	
<b>Үйлдвэрийн ослоо урьдчилан сэргийлэх</b>					
Үйлдвэрлэлийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сэргөөр нөлөөлж үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг сахиулж, хэрэгжилтэнд хяналт тавих  Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалтыг тогтмол хугацаанд гүйцэтгэх	Төслийн хэмжээнд Нийт ажилчдад	0.8	2024 он	M^84990:2000 M^84969:2000
<b>Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө</b>					
	Галын аюулаас урьдчилан сэргийлэх сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах		1.0	3-р улиралд	
	Тэсрэх бодисын агуулах, ШТМ-ын агуулах, химийн бодисын агуулахын аюулгүйн бүсийг тогтоож, дэглэмийг мөрдөж ажиллах	Тэсрэх агуулах бодисын	Үйл ажиллагааны зардал	Үйл ажиллагааны турш	Тэсэлгээний аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм
<b>Химийн бодисын эрсдэлээс урьдчилан сэргийлэх</b>					
Химийн бодисын хадгалалт, ашиглалтын стандарт, дүрэм журам мөрдөөгүй улмаас болзошгүй эрсдэл үүсэх	Химийн бодисын аюулгүй ажиллагааны зааварчилгаа, журам төлөвлөгөө, хор аюулын лавлах мэдээлэл боловсруулах, олшруулах, хэвлэх, ажлын байр бүрт болон агуулах, гадаа талбайд байрлуулах	“Эм эл цахиурт овоо” ХХК	1.2	Ажил эхлэхээс өмнө	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль M84992:2000 M^85029:2011 M^86458:2014
	Химийн бодис, бүтээгдэхүүний сав баглаа боодлыг цуглуулах, аюулгүй хадгалах, хоргүйжүүлэн зайлцуулах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу мэргэжлийн байгууллагын зөвшөөрөлтэйгээр зориулалтын цэгт тээвэрлэн хүргэх	“Эм эл цахиурт овоо” ХХК	Мэргэжлийн байгууллагатай гэрээ хийх	Үйл ажиллагааны турш	

Аюултай хог хаягдаас үүсэх сорөг нөлөөллийг бууруулах, ариглах арга хэмжээ				
	Үйлдвэрийн хатуу, шингэн хог хаягдал дахь химийн бодисын үлдэгдэл хэмжээг тодорхойлох хяналт шинжилгээ хийх	“Эм эл цахиурт овоо” ХХК	Үйл ажиллагааны төсөвт суулгах	Улирал бүр
	хаягдал хадгалах далаангаас хаягдал, түүн дэх металлын оксидууд болон зарим хүнд хортой металлууд (Си, 2п, РЬ, Мп, Сг, Аз, М г.м.), металл бишүүд (Р, 8) уусан нэвчиж газрын доорхи усыг бохирдуулах эрдэлтэй байх магадлал байна.	Хаягдал хадгалах далаан нь нэвчилтийг цуглуулах суваг, хоолой, далаан дээрхий урсацыг цуглуулан зохицуулж, хаягдал хадгалах далаан руу буцаан нийлүүлэхээр байгуулагдсан байх /хөрөнгө оруулалт/	Үйлдвэр ажиллах хугацаанд Төслийн нийт арга хэмжээнд	YAT-нд тусгах
Төсөлд хэрэглэгдэж буй тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжүүдээс гарах аюултай хог хаягдаасаас үзүүлэх	Төсөлд хэрэглэгдэж буй тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжүүдээс гарах аюултай хог хаягдаасаас үзүүлэх		Тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн эрх бүхий байгууллагуудтай гэрээ байгуулан нийлүүлэх	4-р улиралд БОАЖСайдын 2017 оны 12 сарын 12-ны өдрийн А-349-р тушаал
Нийт зардал		Жил 5.0 сая.төг		

## 8. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

сар өдөр	Хаана	Тайлбар
10-1-ний дотор	Багийн Иргэдийн нийтийн хуралд	Урьд оны төлөвлөгөөний биелэлтийг хэлэлцүүлэх
11-1-ний дотор	Аймгийн байгаль орчны газар	Урьд оны төлөвлөгөөний биелэлтийг дүгнүүлэх
12-1	БОНХЯ-ны ХБОБНҮГ-т *Жил бүрийн	Ирэх оны төлөвлөгөөг батлуулах

## 9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

“Цахиурт овоо” төмөр молибгдений уурхай нойтон соронзон аргаар баяжуулах үйлдвэрийн хэмжээнд 2024 онд БОМТөлөвлөгөөнүүдэд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэхэд удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө болон шаардагдах зардлыг тусгасан болно.

№	Авах арга хэмжээ	Мян.төг	Хамтран хэрэгжүүлэгч	Гарах үр дүн
2	Байгаль орчны хамгаалах, хог хаягдлаа тогтоосон цэгт хаях, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар сурталчилгааны самбар гаргаж, шинэчилж байх	1500,0	-	Ажилчдын байгаль орчны боловсролыг дээшлүүлж, хувь хүнээс үүдэлтэй бохирдлыг бууруулах
3	Гал түймэртэй тэмцэх багаж, хэрэгээл, тоног төхөөрөмж авах, хөдөлмөр хамгаалал, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний тоноглолуудыг зохих газарт байнга бэлэн байлгах	5000,0	Мэргэжлийн байгууллага	Гал түймрийн аюул, эредэлээс бүрэн сэргийлэх
4	Ажиллагедыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, эрүүл мэндийн тандалт судалгаа хийх	Дотоод зардааар	Эрүүл мэндийн байгууллага	Ажилчдыг үйлдвэрийн болон бусад гаралтай өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх
5	Галын аюулгүй байдлын дүгнэлтийг дүүргийн Онцгой байдлын хэлтсээр гаргуулах	-	Аймгийн онцгой байдлын хэлтэс	Гал түймрийн аюул, эредэлээс бүрэн сэргийлэх

			Орон нутгийн удирдлага	
6	Нийгмийн хариуцлагын хүрээнд байгалийн гамшгийн үед Уулбаян суманд техникээ ашиглуулах	Дотоод зардлаар		
7	Баяжуулах үйлдвэрийн хаягдлын санг стандартын дагуу шинэчлэх			
8	Хурын ус цуглуулах хөв цөөрөм байгуулж усыг баяжуулах үйлдвэрт ашиглах	Дотоод зардлаар		
НИ ЙТ	6500,0 млн.тог			

#### 10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөний салшгүй нэг хэсэг бөгөөд төслийн үйл ажиллагаа байгаль орчин, нутгийн иргэд, ажиллагсадын амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, хүрээлэн буй орчны бүрдлүүд бүр дээр холбогдох итгэмжлэгдсэн лабораториудаар хяналт шинжилгээг хийлгэж стандартын шаардлагыг хангаж байгаа эсэх талаар анализ хийж зөрчил илэрсэн тохиолдолд бууруулах, арилгах арга хэмжээ авах шаардлагатай.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт нөлөөлөлд өртөх болон өртөж болзошгүй байгаль орчны бүрдэл хэсгүүд, тэдгээрийн төлөв байдлыг тодорхойлох үзүүлэлтүүд, төсөл хэрэгжих орчинд амьдардаг, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн амьжиргаа, нийгмийн болон эрүүл мэндийн байдлыг илтгэх гол үзүүлэлтүүд, тэдгээрт хэмжилт, дээжлэлт хийх шинжилгээний аргууд, хяналтын цэгийн байршил, хяналт хийх хугацаа ба давтамжийг тодорхойлон оруулна. Мөн уг ажлын хэмжээг хэмжих нэгж, нэгжийн үнэ, нийт зардал, баримтлах стандарт, аргазүй, аргачлалыг тусгана.

Үйлдвэр ажиллах явцад байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүрт үзүүлэх аливаа сөрөг нөлөөлөл, түүнийг хянах хэлбэр, хяналт шинжилгээний зайлшгүй шаардлагатай үзүүлэлтүүд, сорыц дээж авах болон хэмжилт хийх цэгийн байршил, хяналт

шинжилгээ хийх хугацаа, давтамж, шинжилгээний арга аргачлал, шаардагдах зардал зэргийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав.

Орчны хяналт шинжилгээний ажлыг хэрэгжүүлэхдээ төсөл хэрэгжүүлэгчийн байгаль орчны асуудал хариуцсан ажилтан хээрийн хэмжилт дээжлэлийг хийх ба үр дунг тайлagnaадаа Монгол улсын холбогдох мөрдөж харьцуулах , итгэмжлэгдсэн лабораториудад шинжилгээ хийлгэх, эрх бүхий субъектээр дүгнэлт гаргуулах хэлбэрээр ажиллана.

Орчны хяналт шинжилгээний ажлыг жил бүрийн байгаль орчны менежмент төлөвлөгөөний биелэлтийн тайландаа оруулж байгаль орчны асуудал эрхэлсэн орон нутгийн болон төрийн захирагааны төв байгууллагад тайлagnана. Мөн байгууллагын дотоодын хяналтыг хэрэгжүүлэх, төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй серөг нөлөөллийг тухай бүр хянах, цаг алдалгүй хариу арга хэмжээ авах зорилгоор байгаль орчны асуудал хариуцсан ажилтан улирал тутам хяналт шинжилгээний дүн мэдээгээр тайлан бэлтгэж, зохих удирдлагадаа тайлagnана.

Хүснэгт 19. Орчны хяналт шинжилгээний хотолбор

Бүрэлдэхүүн	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал мян.төг/жил	Баримтлах стандарт ба арга аргачлал
Агаарын чанар	Температур, Агаарын урсгал, Чийгшил, O <sub>2</sub> , 802, ^O <sub>2</sub> , CO, г.м  Агаарын тоосжилт	1. Уурхайн карьер 2. Хөрсний овоолго 3.Ажилчдын тосгон 4. Баяжуулах үйлдвэр 5. Тэсрэх бодисын агуулах	5 цэгт жилд 1 удаа.  /Шаардлагатай тохиолдолд тухай бүрд /	24 цагийн хэмжилт хийж (8O <sub>2</sub> , ^O <sub>2</sub> , CO , цаг агаарын үзүүлэлт)-ийг хамт тооцоход 150.0 мян.төг PM10, PM2.5, Нийт тоос 150.0 мян.төг	300,0	- M^83113:1981. Агаар мандлын бохирдлыг хэмжих аргачлалын ерөнхий шаардлага - M^80017-2-3-16:1988. Агаар мандал-Хот, суурингийн агаарын бохирдлын шинжилгээ - M^83384:1982. Агаар мандал-Агаарын дээжилт шинжилгээ - M^83113:1981. Хорт утааны ялгаралтыг хэмжих арга - M^85061:2001.



					Нүүрс хүчлийн ХИЙ-CO <sub>2</sub> тодорхойлох эзэлхүүний арга М^80012-014:1991. Ажлын байрны агаар-Бичил орчинг шинжлэх арга
Хөрсөн бүрхэвч	Хөрсний үе давхаргын зузаан (см), элэгдэл эвдрэлийн нөхцөл, ялзмаг %, pH, давсжилт, чийгшилт, Физик шинж чанар, органик бодис, нийт азот, карбонат, Ca, Mg, P <sub>2</sub> O <sub>5</sub> , K <sub>2</sub> O, хөрсөн дэх нефтийн бүтээгдэхүүн	1. Уурхайн карьер 2. Бутлуур, үйлдвэрийн ойролцоо 3. Засварын газар 4. ШТС 5. Хогийн цэг 6. Шимит хөрсний овоолго 7. Тэсрэх бодисын агуулах 8. Хаягдлын далан Кемп	Жилд 2 удаа, 9 цэг дээр 5-6 сард 9-10 сард	Хөрсний механик бүрэлдэхүүн, Химиин бүрэлдэхүүн  Хөрсний хүнд металл шинжилгээний үнэ 50.0 мян.төг  *Газарзүйн хүрээлэнгийн үнэ авав.	900,0  - М^83985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл - М^83310-91 Хөрсний агро химиин үзүүлэлтийг тодорхойлох - М^82305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалахжурам М^8(18O)4814:1999. Атом Шингээлтийн Спектрометрээр шинжилгээ хийх
Усан орчин	Усны pH, цахилгаан дамжуулах чадвар нүүрстөрөгчийн исэл, ерөнхий хими бактериологийн бүрэн шинжилгээ	Уурхайн ундны усны эх үүсвэрээс /Гүний худаг/  Бохир усны шинжилгээ	Жилд 2 удаа	Усны ерөнхий химиин шинжилгээ 100.0 мян.төг Усны 23 элемент хүнд металлын шинжилгээ 100.0 мян.төг Хими бактериологийн бүрэн шинжилгээний үнэ 140 мян.төг	960 мян.төг  - М^80900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ - М^83935:1986 Ундны ус-Усны шинжилгээнд тавигдах шаардлага - М^83936:1986

				*2 <b>*УСУГ итгэмжлэгдсэн лабораторийн үнэ</b>		Үндны ус болон үйлдвэрийн ус-Тухайн талбарт нь шинжилгээ хийх - М^84432:1997 Үндны ус-Хуурай үлдэгдлийн хэмжээг тодорхойлох - М^83934:1986 Үндны болон үйлдвэрийн ус-Химиийн шинжилгээ хийх-дээж авах, хадгалах, зөөвөрлөх - М^85667-10:2001 Усны чанар- Дээж авах-2-р бүлэг. Хаягдал уснаас дээж авах - М^85667-2:2001 Усны чанар- Дээж авах-2-р бүлэг Дээж авах арга М^84867:1999 Усны chanar-Дээж авах-3-р бүлэг Авсан дээжийг зөөвөрлөх, хадгалах арга
Ургамлан нөмрөг	Ургамал	Хээрийн судалгаа, суурин судалгаа	Үйлдвэр орчмын ургамлын бүрхэц, зүйлийн бүрдлийн судалгаа Төсөл хэрэгжих талбай орчмын амьтны аймаг	Жилд 1 удаа	1000,0	Мэргэжлийн байгууллага, мэргэжийн биологичноор хийлгэнэ.
Амьтны аймаг	Амьтан	Хээрийн судалгаа, тухайн орон нутагт хэрэгжиж буй амьтан хамгаалах арга	Жилд 1 удаа		1000,0	Мэргэжлийн байгууллага, мэргэжлийн амьтан судлаачтай хамтран ажиллах

“Цахиурт овоо төмөр, молибденийн ордыг ил аргаар ашиглах, баяжуулах үйлдвэр”  
төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2025

	ХЭМЖЭЭНД оролцох				
<b>4200,0 млн.төг</b>					



Зураг 18. Мониторингийн цэгүүдийн байршил

Comment [SD1]: Зургийн дугаар тавих

### 11. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

Зураг 19. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

#### Зардлын хэмжээ, мян.тог

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	
Серог нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарах зардал	10,450.00
Нохон сэргээлт, ногоон байгууламжийн төлөвлөгөө	10,827.70
Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зардал	9,600.00
Химиин хортай аюултай бодисын эрсдэл, осол эредлийн менежментийн төлөвлөгөө	4,850.00
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал	3,800.00
Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарах зардал	6,500.00
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гарах зардал	4,200.00
<b>Нийт/ мян.тог</b>	<b>50,227.70</b>

“ “ЭМ ЭЛ Цахиурт Овоо” ХХК-ийн Цахиурт Овоо төмөр молибдены ордын ашиглалтын болон хүдрийг нойтон соронзон аргаар баяжуулах үйлдвэрийн БОМТ-нд тусгагдсан ажлуудыг хийхэд дээрхи хүснэгтэнд заасаны дагуу нийт **50,227,700 сая.тог** зарцуулахаар төлөвлөлөө.

Бид уг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартын дагуу гүйцэтгэх болно.

“Цахиурт овоо төмөр, молибдений ордыг ил аргаар ашиглах, баяжуулах үйлдвэр”  
төслийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

2025

“Эм Эл Цахиурт Овоо” ХХК

46